



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 11 сарын 24 өдөр

Дугаар А/714

Ховд

1, 2 дугаар 24 айлын чиглэлийн 2 дугаар хэлхээний шугам шинэчлэх ажлыг хүлээн авах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ын "б", Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийн 1 дүгээр хавсралтын 2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар "Тэгш стандарт" ХХК-ийн хийж гүйцэтгэсэн 1,2 дүгээр 24 айлын чиглэлийн 2 дугаар хэлхээний шугам шинэчлэх ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч: Б.Туулайтулга - Жаргалант сумын Засаг даргын орлогч

Гишүүд: Н.Цацралцэцэг - Мэргэжлийн хяналтын газрын эрчим хүчний хяналтын Улсын байцаагч

Р.Янжмаа - Аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн орон тооны гишүүн

Б.Түмэндэмбэрэл - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

Ц.Цолмонбаатар - Стандарт, хэмжил зүйн хэлтсийн салбар сан хариуцсан мэргэжилтэн

Г.Тунгалаг - Жаргалант сумын Захирагчийн ажлын албаны мэргэжилтэн

Ц. Бэхбаяр - Магсаржав багийн Нийгмийн ажилтан

2.

Д.Энхсайхан - “Ховд дулааны станц” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал

Т.Бямбатөмөр - “Ховд дулаан станц” ТӨХК-ийн ерөнхий инженер

Б.Түмэнжаргал - Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн

С.Батдорж - Аймгийн Архивын тасгийн дарга

Г.Цэрэнханд - “Тэгш стандарт” ХХК-ийн захирал

Нарийн бичгийн

дарга: С.Өнөржаргал - Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дэд бүтэц хариуцсан мэргэжилтэн

2. “Тэгш стандарт” ХХК-ийн хийж гүйцэтгэсэн ажлыг захиалагчаас өгөгдсөн ажлын тоо хэмжээтэй тулган шалгаж, өмч бүртгэлд тусгаж хүлээн авах эсэх талаар шийдвэр гарган танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /Б.Туулайтулга/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН